



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар 319

Улаанбаатар хот

Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг
ашиглуулах гэрээ байгуулах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, 27 дугаар зүйлийн 27.1, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 65 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2,081,726,270.00 (хоёр тэрбум наян нэгэн сая долоон зуун хорин зургаан мянга хоёр зуун далан) төгрөгийн балансын үнэ бүхий Хан-Уул дүүргийн 15 дугаар хороонд байрлах 5,235 м.кв талбай бүхий 6 давхар барилгад Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимыг ашиглалтын зардлаар байршуулахыг зөвшөөрсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дэд дарга А.Дагвадорж, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын ерөнхийлөгч О.Амартувшин нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг ашиглуулах гэрээ байгуулах, акт үйлдэн хүлээлцэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2 Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг ашиглуулах гэрээг 3 жилээр байгуулах;

2.3 Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж ажиллах;

2.4 Барилгыг төрийн байгууллагаас зохион байгуулах арга хэмжээнд үнэ төлбөргүй ашиглуулах;

2.5 Барилгад төрийн байгууллагаас бусад иргэн хуулийн этгээдийг байршуулах, түрээслүүлэх тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай гэрээ байгуулж төлбөрийг улсын төсөвт төвлөрүүлэх;

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс, Захиргаа, удирдлагын албанд тус тус даалгасугай.

ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ЧУРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ



000500